



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/123-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШУ	Шинжлэх ухаан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил
ДЗОУБ	Дэлхийн зон олон улсын байгууллага



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА**

2025.02.25 № 107-2025/МЗ/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яам, аймгийн Боловсролын газар, ДЗМОУБ, Боловсролын ерөнхий газраас 140,935.4 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, зурагт, хяналтын камер, сурагч ширээ, сандал зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээж авсан байна.

**Аудитын гол асуудал**

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

432502251

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайл анд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>468,328,493.10</b>	<b>425,890,270.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	257,212,403.24	196,338,386.92
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	257,212,403.24	196,338,386.92
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	257,212,403.24	196,338,386.92
31211	Төрийн сангийн харилцах	257,212,403.24	196,338,386.92
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	5,310,047.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	5,310,047.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	211,116,089.86	224,241,836.79
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	116,400.00	350,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	350,000.00
35130	Эм боох материал	116,400.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	210,999,689.86	223,891,836.79
35410	Бичиг хэргийн материал	-	183,600.00
35420	Аж ахуйн материал	572,600.00	-
35440	Түлш, шатах тослох материал	-	390,000.00
35460	Хүнсний материал	1,194,000.00	1,089,450.00
35470	Бусад хангамжийн материал	209,233,089.86	222,228,786.79
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,039,162,621.14</b>	<b>1,093,621,039.46</b>
<b>39</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	1,039,162,621.14	1,093,621,039.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	852,456,121.14	908,155,789.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	766,007,185.68	766,007,185.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(224,259,522.12)	(269,334,945.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	405,514,899.77	525,009,222.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(246,646,467.98)	(287,257,152.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	252,499,522.33	281,399,486.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(146,481,447.02)	(164,411,250.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,831,291.50	37,906,291.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,567,951.92)	(18,237,414.05)
39217	Ном	27,558,610.90	37,074,364.90
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	186,706,500.00	185,465,250.00
39301	Програм хангамж	6,545,000.00	6,545,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,982,500.00)	(4,223,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	183,144,000.00	183,144,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,507,491,114.24</b>	<b>1,519,511,310.17</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>485,639.51</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	485,639.51
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	485,639.51
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	485,639.51
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,507,491,114.24</b>	<b>1,519,025,670.66</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,507,491,114.24	1,519,025,670.66
511	Засгийн газрын капитал орон нутгийн сан	698,142,362.18	698,142,362.18
51101	Өмч: - төрийн	698,142,362.18	698,142,362.18
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(410,307,164.54)	(398,772,608.12)

51210	Өмнөх үеийн үр дүн	(410,307,164.54)	(410,307,164.54)
51220	Тайлант үеийн үр дүн	-	11,534,556.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,219,655,916.60	1,219,655,916.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,507,491,114.24</b>	<b>1,519,511,310.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,066,810,787.31</b>	<b>2,725,344,314.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>105,894,246.38</b>	<b>225,621,046.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	105,894,246.38	225,621,046.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,894,246.38	225,551,046.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,382,200.00	4,783,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,811,300.00	62,501,750.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,700,746.38	158,265,796.50
120009	Бусад орлого	-	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,960,916,540.93</b>	<b>2,499,723,268.27</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,825,368,100.00	2,376,404,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,825,368,100.00	2,376,404,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	150,648.00	90,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн д хуваарилсан хөрөнгө	150,648.00	90,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	135,397,792.93	123,229,068.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,397,792.93	123,229,068.27
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,030,327,774.17</b>	<b>2,713,809,758.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,030,327,774.17</b>	<b>2,713,809,758.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,896,688,171.17	2,587,354,625.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,299,917,633.76	1,902,410,475.00
210101	Үндсэн цалин	877,194,850.00	1,141,837,282.54
210102	Нэмэгдэл	370,496,607.01	616,422,572.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	62,675,000.00
210104	Урамшуулал	52,226,176.75	81,475,620.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	161,757,825.32	226,726,340.95
210201	Тэтгэврийн даатгал	112,200,498.25	157,042,882.58
210202	Тэтгэмжийн даатгал	13,196,932.84	18,963,123.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,407,946.30	9,399,062.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,343,612.45	8,223,028.59
210205	Эрүүл мэндийн даатгал	23,608,835.48	33,098,244.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	116,265,792.93	99,229,068.27
210301	Гэрэл, цахилгаан	18,020,682.73	19,731,639.27
210302	Түлш, халаалт	81,746,416.20	61,061,835.00
210303	Цэвэр, бохир ус	16,498,694.00	18,435,594.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	44,457,227.57
210408	Бараа материал акталсны зардал	-	44,457,227.57
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,491,780.00	18,925,000.00
210604	Урсгал засвар	7,491,780.00	18,925,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,608,364.36	46,470,095.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,382,200.00	4,783,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,226,164.36	41,686,595.75
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	295,646,774.80	249,136,417.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,246,140.00	116,904,583.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,077,788.72	23,705,212.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	200,322,846.08	108,526,622.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	133,639,603.00	126,455,133.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	133,639,603.00	126,455,133.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	112,928,303.00	114,436,733.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,711,300.00	12,018,400.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>36,483,013.14</b>	<b>11,534,556.42</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	21,616,588.73	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,616,588.73	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(21,616,588.73)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,866,424.41</b>	<b>11,534,556.42</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,008,110,040.93</b>	<b>2,567,078,518.27</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>47,193,500.00</b>	<b>67,355,250.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	47,193,500.00	67,355,250.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	47,193,500.00	67,285,250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,382,200.00	4,783,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,811,300.00	62,501,750.00
120009	Бусад орлого	-	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,960,916,540.93</b>	<b>2,499,723,268.27</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,825,368,100.00	2,376,404,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,825,368,100.00	2,376,404,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	150,648.00	90,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн хуваарилсан хөрөнгө	150,648.00	90,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	135,397,792.93	123,229,068.27
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,397,792.93	123,229,068.27
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,834,514,739.37</b>	<b>2,605,902,907.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,834,514,739.37</b>	<b>2,605,902,907.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,699,733,486.37</b>	<b>2,479,552,324.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,299,917,633.76	1,906,077,865.11
210101	Үндсэн цалин	876,033,304.04	1,153,364,693.55
210102	Нэмэгдэл	367,699,609.14	605,934,791.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	62,314,970.05
210104	Урамшуулал	56,184,720.58	84,463,410.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	161,757,825.32	227,883,358.33
210201	Тэтгэврийн даатгал	111,362,060.03	156,533,102.93
210202	Тэтгэмжийн даатгал	13,033,777.10	18,809,524.97

210203	ҮОМШӨ-ний даатгал	10,352,301.74	10,129,397.29
210204	Ажилгүйдлийн даатгал	2,445,197.80	7,846,204.74
210205	Эрүүл мэндийн даатгал	24,564,488.65	34,565,128.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>116,265,792.93</b>	<b>99,229,068.27</b>
210301	Гэрэл, цахилгаан	18,020,682.73	19,731,639.27
210302	Түлш, халаалт	81,746,416.20	61,061,835.00
210303	Цэвэр, бохир ус	16,498,694.00	18,435,594.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,867,940.00</b>	<b>-</b>
210502	Хоол, хүнс	2,867,940.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,000,000.00</b>	<b>18,925,000.00</b>
210604	Урсгал засвар	10,000,000.00	18,925,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,148,364.36</b>	<b>46,560,662.38</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,382,200.00	4,783,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,766,164.36	41,777,162.38
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>91,775,930.00</b>	<b>180,876,370.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,527,630.00	158,598,609.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,248,300.00	22,277,761.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>134,781,253.00</b>	<b>126,350,583.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>134,781,253.00</b>	<b>126,350,583.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	114,069,953.00	114,332,183.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,711,300.00	12,018,400.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>173,595,301.56</b>	<b>(38,824,389.32)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>74,309,000.00</b>	<b>22,049,627.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>74,309,000.00</b>	<b>22,049,627.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>74,309,000.00</b>	<b>22,049,627.00</b>
222001	Тоног төхөөрөмж	49,940,000.00	10,054,627.00
223001	Бусад хөрөнгө	24,369,000.00	11,995,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(74,309,000.00)</b>	<b>(22,049,627.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>99,286,301.56</b>	<b>(60,874,016.32)</b>

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		257,212,403.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	257,212,403.24	196,338,386.92

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	698,142,362.18	1,220,156,547.20	-425,674,219.55	1,492,624,689.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			500,630.60	500,630.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	698,142,362.18	1,220,156,547.20	-425,173,588.95	1,493,125,320.43
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-500,630.60		-500,630.60
9	Тайлант үеийн үр дүн			11,534,556.42	11,534,556.42
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	698,142,362.18	1,219,655,916.60	-398,772,608.12	1,519,025,670.17

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,819,177,369.00	2,627,952,534.59	191,224,834.41	93.2
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,819,177,369.00	2,627,952,534.59	191,224,834.41	93.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,670,939,069.00	2,501,601,951.59	169,337,117.41	93.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,019,177,900.00	1,906,077,865.11	113,100,034.89	94.4
210101	Үндсэн цалин	1,329,876,200.00	1,153,364,693.55	176,511,506.45	86.7
210102	Нэмэгдэл	630,758,000.00	605,934,791.51	24,823,208.49	96.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт		62,314,970.05	-62,314,970.05	
210104	Урамшуулал	58,543,700.00	84,463,410.00	-25,919,710.00	144.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	252,397,200.00	227,883,358.33	24,513,841.67	90.3
210201	Тэтгэврийн даатгал	171,630,100.00	156,533,102.93	15,096,997.07	91.2
210202	Тэтгэмжийн даатгал	20,191,800.00	18,809,524.97	1,382,275.03	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,095,900.00	10,129,397.29	33,497.29	100.3
210204	Ажилгүйдлийн даатгал	10,095,900.00	7,846,204.74	2,249,695.26	77.7
210205	Эрүүл мэндийн даатгал	40,383,500.00	34,565,128.40	5,818,371.60	85.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	99,229,069.00	99,229,068.27	0.73	100.0
210301	Гэрэл, цахилгаан	19,731,640.00	19,731,639.27	0.73	100.0
210302	Түлш, халаалт	61,061,835.00	61,061,835.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	18,435,594.00	18,435,594.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,000,000.00	24,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	24,000,000.00	24,000,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	63,366,100.00	46,560,662.38	16,805,437.62	73.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,783,500.00	4,783,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	58,582,600.00	41,777,162.38	16,805,437.62	71.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	212,768,800.00	197,850,997.50	14,917,802.50	93.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	190,490,900.00	175,573,236.50	14,917,663.50	92.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,277,900.00	22,277,761.00	139.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	148,238,300.00	126,350,583.00	21,887,717.00	85.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	136,219,900.00	114,332,183.00	21,887,717.00	83.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,018,400.00	12,018,400.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,819,177,369.00</b>	2,567,008,518.27	252,168,850.73	91.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,376,404,200.00</b>	2,376,494,200.00	-	100.0

131001	Улсын төсвөөс санхүүжих	2,376,404,200.00	2,376,404,200.00	-	100.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	90,000.00	-90,000.00	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>123,229,069.00</b>	123,229,068.27	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	123,229,069.00	123,229,068.27	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>319,544,100.00</b>	67,285,250.00	-67,285,250.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,783,500.00	4,783,500.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,760,800.00	62,501,750.00	3,740,950.00	106.4
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	255,999,800.00		255,999,800.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	257,212,403.24	-257,212,403.24	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	196,338,386.92	-196,338,386.92	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>77</b>	<b>69</b>	<b>8</b>	<b>89.6</b>
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	60	53	7	88.3
620003	Үйлчлэх ажилтан	16	15	1	93.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь “Аз жаргалтай, аливаад хариуцлагатай суралцагч” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.
- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,020.20 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	257,212.40	196,338.30	(60,874.10)
Авлага		5,310.10	5,310.10
Бараа материал	211,116.10	224,241.80	13,125.70
Үндсэн хөрөнгө	1,039,162.60	1,093,621.00	54,458.40
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,507,491.10</b>	<b>1,519,511.30</b>	<b>12,020.20</b>
Өр төлбөр		485.60	485.60
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,507,491.10	1,519,025.60	11,534.50
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,507,491.10</b>	<b>1,519,511.30</b>	<b>12,020.20</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 196,338.30 мянган төгрөг байгаа нь төсвийн хэмнэлттэй холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 224,241.80 мянган төгрөг болж 13,125.70 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Боловсролын газар, Боловсролын ерөнхий газраас нийт 17,330.3 мянган төгрөгийн сурах бичиг, бусад бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 270,832.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэснээр өссөн болон 275,036.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,093,621.00 мянган төгрөг болж 54,458.40 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 22,049.6 мянган төгрөгийн компьютер, тавилга худалдан авсан, БШУЯ, аймгийн Боловсролын газар, ДЗМОУБ, Боловсролын ерөнхий газраас 140,935.4 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, телевизор, хяналтын дотор камер, сурагчийн ширээ зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 108,526.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,294,488.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас 350,170.2 мянган төгрөгөөр бууруулан 1,944,318.3 мянган төгрөгөөр баталсан боловч төсвийн жилийн дундуур төсөвт 9 удаагийн зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 2,376,404.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 123,229.1 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 255,999.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,783.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 58,760.8 мянган төгрөг зэрэг нийт 2,819,177.4 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 2,376,404.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 123,229.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,783.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 62,501.8 мянган төгрөг, бусад орлого 70.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн хуваарилсан 90.0 мянган төгрөг нийт 2,567,078.5 мянган төгрөг мянган төгрөг төвлөрүүлж, 2,627,952.5 мянган төгрөгийг зарцуулж, 191,224.8 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,627,952.5 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь байр ашиглалтын зардлыг 0.3 мянган төгрөгөөр, хүүхэд хамгааллын зардлыг 6.9 мянган төгрөгөөр, сургалт семинарын зардлыг 1,419.1 мянган төгрөгөөр, эрүүл мэндийг дэмжих зардлыг 456.1 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 21,887.8 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх зардлыг 7,701.9 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 126,960.3 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааны зардлыг 26,763.9 мянган төгрөгөөр, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн зардлыг 3,028.4 мянган төгрөг, сургуулийн нэмэлт хөтөлбөрийн зардлыг 2,979.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	5,547.0	5,546.7	0.3	100.0
2	80233- Хүүхэд хамгаалал	5,846.2	5,839.3	6.9	99.9
3	80312 - Сургалт семинар	4,288.1	2,869.0	1,419.1	66.9
4	81605 - Эрүүл мэндийг дэмжих	10,044.1	9,588.0	456.1	95.5
5	81801 - Үдийн цай хөтөлбөр	136,219.9	114,332.1	21,887.8	83.9

6	81816 - Хүүхдэд ээлтэй орчин	50,131.6	50,131.6	-	100.0
7	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	16,641.6	8,939.7	7,701.9	53.7
8	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,306,204.1	2,179,243.8	126,960.3	94.5
9	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	81,694.7	54,930.8	26,763.9	67.2
10	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	60,401.7	57,373.3	3,028.4	95.0
11	81848-Сурах бичиг түрээс	4,783.5	4,783.5	-	100.0
12	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр	14,034.7	11,055.7	2,979.0	78.8
13	83603-Нэмэлт төсөв	91.1			
<b>Дүн</b>		<b>2,695,948.3</b>	<b>2,504,723.5</b>	<b>191,224.8</b>	<b>92.9</b>
14	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	123,229.0	123,229.0	-	100.0
<b>Нийт</b>		<b>2,819,177.3</b>	<b>2,627,952.5</b>	<b>191,224.8</b>	<b>93.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг үндсэн дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 6 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул Цахим Ертөнц ХХК, НомунСэлэнгэ ХХК, Алтантариа ХХК, иргэн С.Майнбаяр, О.Доржцэмбэ, С.Энхтайван, Ц. Цэсэм, Б. Батхүү нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Мөн төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулах болон анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,030,327.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 30,454.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар бүрдэл дутуу анхан шатны баримтуудыг нөхөн бүрдүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өгсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1		100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>		<b>1</b>		<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх” арга хэмжээний зарцуулалтыг нарийвчлан хянаж үзэх нь зүйтэй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 4 зөрчил<sup>1</sup> илрүүлж, **6,614.0** мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Албан шаардлага

1. Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Б/ 110 дугаар шийдвэрээр сургалтын менежер албан тушаалтай Х.Амарсүрэнгийн үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн хугацааны 6,810.0 мянган төгрөгийн цалин хөлсийг байгууллагаас барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар 1,500.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, **5,310.0** мянган төгрөгийг нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

этгээдээр буцааж төлүүлнэ”, “Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үлдэгдэл нөхөн төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлэх.

**2.** Байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос сурагчдын шинэ жилийн бэлгэнд **1,304.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

## **5.2 Зөвлөмж**

### **1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт**: Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих цайны газрын тайлан тооцоо гаргаагүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж**: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

### **2. Зардлын данстай холбоотой асуудал:**

**Илрүүлэлт**: Зайлшгүй шаардлагын улмаас илүү цагаар ажиллуулсан, ажил үүргийг хавсруулан гүйцэтгэсэн гэх үндэслэлээр нэмэгдэл цалин хөлс олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Эрэгтэй багш нарыг дулааны шугам засварлуулах ажилд ажиллуулсан, сургалтын менежерийг хариуцлагатай жижүүр хийсэн гэх үндэслэлээр хичээл заасан илүү цагаас гадна дахин илүү цагийн нэмэгдэл тооцсон,
- Хүний нөөцийн программ хариуцсан, дотоод хяналт хэрэгжүүлсэн зэрэг орон тоонд батлагдаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн гэх үндэслэлээр хавсран ажилласны нэмэгдэл тооцсон гэх мэт.

**Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Буруутай албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлээгүй	1	5,310.0			1	5,310.0							
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	1,304.0			1	1,304.0							
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан	1						1						
Төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1						1						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>6,614.0</b>			<b>2</b>	<b>6,614.0</b>	<b>2</b>						



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 141/125/0385  
00А-2025/123/НА-СТА-Т123

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Б/ 110 дугаар шийдвэрээр сургалтын менежер албан тушаалтай Х.Амарсүрэнгийн үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн хугацааны 6,810.0 мянган төгрөгийн цалин хөлсийг байгууллагаас барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар 1,500.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, 5,310.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", "Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11 "Хууль тогтоомж ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


- Байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал Д.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Улаанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИГАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504423



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 119/А/250385  
00А-2025/123/НА-СТА-7213

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос сурагчдын шинэ жилийн бэлгэнд 1,304.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.6: "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал Д.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Улаанаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА  
Д.АРИУНАА

432504445

